



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 2/2

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, технологийн хоцрогдолд орж ашиглах боломжгүй болсон, 9 нэрийн, 84,270,849.68 (наян дөрвөн сая хоёр зуун далан мянга найман зуун дөчин есөн төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 52,418,638.70 (тавин хоёр сая дөрвөн зуун арван найман мянга зургаан зуун гучин найман төгрөг далан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дарга П.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг актлах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001044

12-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС
ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Код	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг төгрөг)
Машин тоног төхөөрөмж									
1	271	Өнгөт принтер	2010.12.01	ш	2	389,907.00	779,814.00	779,814.00	-
2	363	Галын хяналтын камер	2010.12.01	ш	2	4,381,254.99	8,762,509.98	3,937,913.90	4,824,596.08
3	366	IR камер/чингэлтэй уул	2010.12.01	ш	1	49,087,991.61	49,087,991.61	22,060,376.71	27,027,614.90
4	2934	Серверийн аккумулятор 200 A/ц	2018.07.10	ш	33	485,000.00	16,005,000.00	16,005,000.00	-
5	749	BGAN EXP500	2011.11.30	ш	1	7,546,734.09	7,546,734.09	7,546,734.09	-
6	2618	Гар станц Unimo	2017.12.26	ш	5	276,000.00	1,380,000.00	1,380,000.00	-
7	3364	Зөөврийн ухаалаг төхөөрөмж (I pad 3G)	2021.12.31	ш	1	273,300.00	273,300.00	273,300.00	-
Хэсгийн дүн							83,835,349.68	51,983,138.70	31,852,210.98
Тавилга, эд хогшил									
8	31	Хувцасны төмөр шүүгээ	2019.12.31	ш	1	145,500.00	145,500.00	145,500.00	-
Хэсгийн дүн							145,500.00	145,500.00	-
Программ хангамж									
9	2865	Акарда дуу хөрвүүлэгч программ	2018.03.20	ш	1	290,000.00	290,000.00	290,000.00	-
Хэсгийн дүн							290,000.00	290,000.00	-

Д/д	Код	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг төгрөг)
		Нийт дүн			47		84,270,849.68	52,418,638.70	31,852,210.98
					(дөчин доллоо)		(наян дөрвөн сая хоёр зуун далан мянга найман зуун дөчин есөн төгрөг жаран найман мөнгө)	(тавин хоёр сая дөрвөн зуун арван найман мянга зургаан зуун гучин найман төгрөг далан мөнгө)	(гучин нэгэн сая найман зуун тавин хоёр мянга хоёр зуун арван төгрөг ерэн найман мөнгө)